



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 01 сарын 25 өдөр

Дугаар А/АЗ

Булган сум

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, Соёлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.1 дэх заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.6 заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. UBS Телевизээс зохион байгуулж буй "Орших уу, эс орших уу" үндэсний хэмжээний шоунд амжилттай оролцож соёл, урлагийн салбарт аймаг, орон нутгийн нэрийг гаргаж, өөрийн авъяас чадвараар 3 дугаар шатанд шалгараад байгаа "Алухай" хамтлагт 500,000 (таван зуун мянган) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Шаардагдах хөрөнгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газар (Д.Алтаншагай)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ